# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар

## 2022 оны жилийн эцэс

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | 1 | Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03 | 39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана. | Орон нутгийн онцлогоос хамааран өвс ургамал тачир, намхан ой хээрийн түймэр гарсан тохиолдол байгаагүй тул жил бүр ой хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардал төсөвт тусгагддаггүй. / | Х.Б | Х.Б | |
| 2 | 2 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 | 18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/79 тушаалын 1 дүгээр хавсралтаар “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”–г баталж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна. | 100% | 70% | |
| | 3 | | 18.1.2.. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч байрлуулахад зориулсан түр хамгаалах байрны төсөл боловсруулан саналыг хүргүүлж Орон нутгийн хөгжлийн сангаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 250,000,000 төгрөгний | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | төсөвт өртөг бүхий “Түр хамгаалах байр бий болгох” саналыг батлуулсан.2022 онд Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь урьдчилан сэргийлэх нөлөөллийн 8 арга хэмжээнд 25,196,950 төсөв зарцуулагдсан байна. | | | |
| | 4 | | 18.1.3.. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Аймгийн хэмжээнд 2022 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 23 бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.7 хувь, энэ төрлийн зөрчил 60 бүртгэгдсэнийг өмнөх он мөн үетэй харьцуулахад 30.4 хувиар тус тус өссөн байна. Орон нутгийн хөгжлийн сангаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 250,000,000 төгрөгний төсөвт өртөх бүхий “Түр хамгаалах байр бий болгох” саналыг шийвэрлүүлсэн.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс | 30% | 30% | |
| | 5 | | 19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 8 чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 10213 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, шалтгаан нөхцөлийг тодорхойлох судалгааг 15 сумын 600 гаруй иргэдээс авч, судалгааны дүнд хүчирхийллийн шалтгаан нөхцөлд гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа үл ойлголцол, архидалт, боловсролын ялгаатай байдал нь дийлэнх хувийг эзэлж байна гэсэн дүгнэлт гарсан байна. Судалгааны дүн дээр үндэслэн Гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, харилцааны тогтвортой байдлыг дэмжих, иргэд олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох зорилгоор 8 төрлийн модуль сургалтын агуулгаар цахим мэдээлэл бэлтгэж, байгууллагын цахим хуудсанд байршуулж, 5 сэдвийн хүрээнд танхимын | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлнэ:) | сургалтуудыг зохион байгуулж нийт 5346 гэр бүлд хүргэж ажиллалаа. | | | |
| | 6 | | 19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хамтарсан багийн дарга, нарийн бичиг нарт NAMS програмд бүртгэх цахим сургалт 1 удаа, танхимын сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт 15 сумын хамтарсан багийн 158 гишүүнийг хамруулж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллалаа. 2022 онд гэр бүлийн хүчирхийллийн 42 кейс бүртгэгдэж, кейс шийдвэрлэлт 94 хувьтай байна. Тус үйл ажиллагаанд 1,894,000 төгрөг зарцуулла. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| | 7 | | 19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | “Түр хамгаалах байр бий болгох” төслийн саналыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, Орон нутгийн хөгжлийн сангаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 250,000,000 төгрөгний төсөвт өртөх бүхий “Түр хамгаалах байр бий болгох” саналыг шийдвэрлүүллээ. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| | 8 | | 19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны зардлын төсвийн төслийг боловсруулан саналыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 30,000,000 төгрөгний төсвийг шийдвэрлүүллээ. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | | | | |
| | 9 | | 19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал үйлчилгээйий зардлын норматив”-ын “Шуурхай тусламж үйлчилгээний зардал”, “Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал”-аар санхүүждэг. 2022 оны байдлаар хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор 7,939,500 төгрөгний төсөв зарцуулагдсан байна. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| | 10 | | 19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: | Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, хүчирхийлэлд өртөж болзошгүй болон эрсдэлт нөхцөлд байгаа иргэдээ бүртгэх, хамгаалах, хариу үйлчилгээг төлөвлөх, хяналтын цахим систем бий болгох зорилгоор Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн дэмжлэгтэйгээр сумдын нийгмийн бодлогын мэргэжилтэн буюу хамтарсан багийн нарийн бичиг, сургуулийн нийгмийн ажилтан нийт 43 нийгмийн ажилтанд иж бүрэн таблет хурууны хээ уншигчийг хүлээлгэн өгч, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллалаа. 2022 оноос Нийгмийн ажилтны мэдээллийн сан www.nams.fcy.mn–ыг хэрэглээнд нэвтрүүлж, Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг цахим мэдээллийн санд бүртгүүлж, үзүүлсэн үйлчилгээний чанарт үндэслэн хамтарсан баг болон нийгмийн ажилтнууд санхүүжилт авах боломжийг бүрдүүлсэн. 2022 онд 5 сумын хамтарсан баг мэдээллийн санд бүргүүлж, 739500 төгрөгний санхүүжилтийг авсан байна. | 70% | 70% | |
| | 11 | | 19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр "Гэрэлтдэг ертөнц" ТББ, "Төгөлдөршил" хувь хүний хөгжлийн төв ТББ, “Монголын хүүхэд, гэр бүл судлалын академи”, Дүүрэн билэг | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | НҮТББ, Илтгэгч Н.Ганбилэг нартай хамтран ажиллах ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, нийт 6 төрлийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Гэрээний биелэлт 100%-тай байна. Тус үйл ажиллагаанд нийт 4,286,400 төгрөгийн төсөв зарцууллаа. | | | |
| | 12 | | 19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, олон нийт, эцэг эх асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн хэмжээнд байгууллага аж ахуйн нэгжийн дэргэдэх 112 эцэг эхийн зөвлөл байгуулагдаж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхи санаачлага гарган ажилласан 3 эцэг эхийн зөвлөлийг “Шилдэг эцэг эхийн зөвлөл”-аар шалгаруулан, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгууллаа. | 100% | 100% | |
| | 13 | | 25.2.. Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно. | Тус аймаг дахь Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасагт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Гэр бүлийн хүчирхийллээс урьчдилан сэргийлэх ахлах мэргэжилтэн-1, хэсгийн байцаагч-2 ажилаж байна. | 100% | 100% | |
| 3 | 14 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж | 2021-2025 онд Дундговь аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2 зорилтын хүрээнд боловсруулан аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулан ажиллаж байна. "Хүний нөөцийг | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2019.01.01 | хэрэгжүүлнэ. | хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт 96 хувьтай байна. Төрийн байгууллагууд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлан хэрэгжилт үр дүнг тооцон ажиллаж байна. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 24 хэлтэс агентлаг, 15 сумын засаг даргын тамгын газарт төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж ажиллах чиглэлийг өгч ажилласнаар төрийн байгууллагууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцон ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | | | |
| 4 | 15 | Коронавирус т халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29 | 16.4.. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл дэх дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж Улсын онцгой комисст хүргүүлнэ. | Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний хүрээнд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан барилга багууламжийн судалгаанд тодотгол хийж дайчилж болох барилгын судалгааг гарган Улсын онцгой комисст хүргүүлж тусгаарлах байр, тусгаарлах эмнэлгээр ашиглах шийдвэрийг гарган хэрэгжилтийг хангуулан ажилласан. | 100% | 100% | |
| 5 | 16 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын | 15.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг | 2021 оны 12 сарын 28-ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 13 дугаар тогтоолоор "Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-ийг баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. тус үндсэн чиглэлийг батлуулахын өмнө Үндэсний хөгжлийн газраар хянуулан зөвлөгөө авч | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01 | хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх баримт бичиг дуусгавар болохоос өмнө батална. /Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./ | сайжруулан АИТХ-аар хэлэлцүүлэн баталсан болно.<br><br>Хавсралт : 1 файл | | | |
| | 17 | | 17.4.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг даргыг томилогдсоны дараах 45 хоногт багтаан батална. | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан Үндэсний хөгжлийн газраар хянуулан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Хуульд заасан хугацаанд боловсруулан холбогдох газраар хянуулан батлуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | 100% | |
| | 18 | | 18.6.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална. | “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална” гэж заасны дагуу аймгийн ИТХ аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөг 2021.12.03- ны өдөр, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг 2022.12.05-ны өдөр тус тус батлаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | 100% | |
| | 19 | | 21.6.. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг, нийслэлийн Засаг даргаас Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын хавсралтад заагдсан хугацаанд бодлогын баримт бичгүүдийн тайланг ЗГХЭГ-ын unelgee.gov.mn цахим программд байршуулахаас гадна цаасаар тайланг хүргүүлж хэвшсэн. Мөн холбогдох яамдад хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Журмын хавсралтад заагсан хугацаанд үндэслэн орон нутагт тусгай тайлан мэдээ авах хуваарийг жил бүрийн эхэнд батлуулан үр дүнг тооцож ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 20 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцсон улирал бүр дүгнэлт, зөвлөмжийг байршуулж хэвшээд байна. Сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ дүгнэлт, байгууллагын төсвийг үр ашигтай захиран зарцуулах чиглэлээрх төсөв санхүүгийн сар, улирлын тайлан, аудитын дүгнэлт зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд dundgovi.gov.mn аймгийн нэгдсэн сайтад нээлттэй ил тод байршуулсан. Мөн 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг тухай бүр нь Ил тод байдал цэсийн аймгаас дэвшүүлсэн зорилт хэсэгт нээлттэй мэдээлсэн. | 100% | 100% | |
| | 21 | | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх хүрээний 24 агентлаг болон төрийн өмчит нийт 31 байгууллага холбогдох заалтын дагуу чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг зэрэг мэдээллээ www.dundgovi.gov.mn аймгийн албан ёсны вэб сайтад байршуулсан. | 100% | 100% | |
| | 22 | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан дүгнэлт зөвлөмжийг www.dundgovi.gov.mn аймгийн албан ёсны вэб сайтад байршуулж хэвшээд байна. | 100% | 100% | |
| | 23 | | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан гэж орон нутгаас гарах боломжгүй | Х.Б | Х.Б | |
| | 24 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийн тайлан; | шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, дүгнэлт зөвлөмжийг www.dundgovi.gov.mn аймгийн албан ёсны вэб сайтад байршуулж хэвшээд байна. | | | |
| | 25 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Төрийн байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, ЗГ-ын тогтоолуудыг нээлттэй ил тод байлгах зорилгоор www.dundgovi.gov.mn аймгийн нэгдсэн сайтын “Эрх зүйн акт” цэсийг Legalinfo эрх зүйн мэдээллийн нэгдсэн системтэй холбон хайлт хийх боломжийг бүрдүүлж, төрийн албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдөх, олон нийт нээлттэй ашиглах боломжийг бүрдүүлсэн. Мөн тус цэсэд АЗД-ын захирамж, ЗДТГ-ын даргын тушаал болон иргэд олон нийтэд хууль эрхзүйн мэдлэг олгох хуулийн подкастуудын байршуулсан. | 100% | 100% | |
| | 26 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Аймгийн ЗД-ын дэргэдэх агентлагууд болон төрийн өмчийн 30 байгууллагын цахим сайт нь www.dundgovi.gov.mn аймгийн нэгдсэн сайтад цахим хуудасны холбоосоор харилцан холбогдох боломжтой бөгөөд тухайн байгууллагуудын албан тушаалтнуудын мэдээллийг төрийн байгууллагууд цэсэд байгууллага бүр нээлттэй ил тод байршуулсан. Мөн аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдийн албан хаагчдын мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтын Засаг даргын Тамгын газар цэсэд хэлтэс тус бүрээр нь олон нийтэд нээлттэй, ил тод байршуулсан. | 100% | 100% | |
| | 27 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн байгууллагуудад иргэдээс цахимаар болон биечлэн, бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүр нэгтгэн www.dundgovi.gov.mn аймгийн нэгдсэн сайтын “Ил тод байдал цэсийн “Өргөдөл гомдол” хэсэгт байршуулсан. | 100% | 100% | |
| | 28 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Дундговь аймгийн нийт хүн ам, нийгэм эдийн засгийн байдал, мал аж ахуй, баг, сургууль, цэцэрлэг, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн статистик мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтад нээлттэй ил тод байршуулсан. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 29 | | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | 2022 онд зохион байгуулсан аймгийн хэмжээний томоохон арга хэмжээнүүдийн хөтөлбөрийг www.dundgovi.gov.mn сайтын Ил тод байдал цэсэд Шинэ санал саначилга хэсэгт байршуулсан. https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=779 | 100% | 100% | |
| | 30 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | сул орон тоог www.dundgovi.gov.mn сайтын хүний нөөцийнил тод байдал цэсэд байршуулж хэвшсэн. https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=655 | 100% | 100% | |
| | 31 | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Тус журмыг www.dundgovi.gov.mn сайтын хүний нөөцийн удирдлагын ил тод байдал цэсэд байршуулсан. https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=655 | 100% | 100% | |
| | 32 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | 2019 оны 33 дугаар тогтоолоор өөрчлөн батлагдсан албан хаагчийн ёс зүйн дүрмийг www.dundgovi.gov.mn аймгийн нэгдсэн сайтын Ил тод байдал цэсийн Хүний нөөц хэсэгт байршуулж олон нийтэд нээлттэй мэдээлж байна. | 100% | 100% | |
| | 33 | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | 2021-2025 онд “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг АИТХ-аар хэлэлцэн батлуулж тус хөтөлбөр болон хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтын хүний нөөцийн стратеги, бодлого цэсэд нээлттэй ил тод байршуулж байна. | 100% | 100% | |
| | 34 | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Аймгийн ЗД-ын захирамжаар 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, “Хандлагаа өөрчилж хамтдаа хөгжье” аян, “Ажлын байран дахь сэтгэл зүйн эрүүл мэнд” хөтөлбөр зэргийг хэрэгжүүлж хэрэгжилтийн талаарх мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтын Ил тод байдал цэсийн хүний нөөц хэсэгт байршуулсан. | 100% | 100% | |
| | 35 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Тус журмыг www.dundgovi.gov.mn сайтын хүний нөөцийн удирдлагын ил тод байдал цэсэд байршуулсан. https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=655 | 100% | 100% | |
| | 36 | | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн | 2023 оны төсвийн төсөл болон 2022 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр нь Ил тод байдал цэсний төсөв санхүү хэсэгт байршуулсан нээлттэй мэдээлсэн. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсөл; | https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=572 | | | |
| | 37 | | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланг www.dundgovi.gov.mn сайтын Төсөв санхүү хэсэгт байршуулсан бөгөөд 2022 оны санхүүгийн тайлан гарах хугацаа болоогүй https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=569 https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=579 | 100% | 100% | |
| | 38 | | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Жил бүрийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг www.dundgovi.gov.mn аймгийн нэгдсэн сайтын Ил тод байдал цэсний Төсөв санхүү хэсэгт байршуулж ил тод мэдээлж байна. https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=573 | 100% | 100% | |
| | 39 | | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Орон нутгийн өмчит 25 хуулийн этгээдийн 199 түрээсийн гэрээг баталгаажуулж түрээсийн орлого 19.5 сая төгрөг, мөн орон нутгийн өмчит байгууллагын акталсан хөрөнгө, барилга, их засвараас гарсан материалыг худалдан борлуулахад хяналт тавьж 47.7 сая төгрөг 2022 онд нийт орон нутгийн орлогын дансанд 67,2 сая төгрөгийг төвлөрүүлж мэдээллийг албан ёсны сайтад ил тод байршуулсан. http://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=227 Мөн түрээсийн үнэ тогтоосон ИТХ-ын тогтоол түрээсийн орлого, архивын орлогын мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтад ил тод нээлттэй байршуулсан. https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=572 | 100% | 100% | |
| | 40 | | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Мөсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг шилэн данс цэсэд байршуулсан. https://www.shilendans.gov.mn/org/41?form=6310195&year=2022&month=12&group=0&task=17 | 100% | 100% | |
| | 41 | | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн данс цэсэд сар бүр тогтмол байршуулсан. https://www.shilendans.gov.mn/org/41?group=1&year=2022 https://www.shilendans.gov.mn/org/41?form=6302048&year=2022&month=12&group=1&task=17 | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 42 | | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг шилэн данс цэсэд дэлгэрэнгүй байршуулсан. https://www.shilendans.gov.mn/org/41?form=6294596&year=2022&month=12&group=0&task=17 | 100% | 100% | |
| | 43 | | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | 2022 оны байдлаар аймагт ийм шийдвэр гараагүй байна. | Х.Б | Х.Б | |
| | 44 | | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Шилэн дансны мэдээллийг тухай бүр нь нээлттэй мэдээлж байна. https://shilendans.gov.mn/org/2539?group=0&year=2022 | 100% | 100% | |
| | 45 | | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам” дагуу зохион байгуулан ажиллаж байна. Тус мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn, dundgovi.gov.mn сайтын төрийн байгууллагын мэдээ хэсэгт, газрын фейсбүүк хуудсаар иргэдэд ил тод нээлттэй хүргэж байна. Мэдээлэл авах линк: | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үндэслэл, шалтгаан; | https://www.tender.gov.mn/mn/result/?year=2022&selGovernorId=142&selClientId=1483427090499& tenderCode=undefined&get=1 | | | |
| | 46 | | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | Аймгийн Төрийн аудитын газраас орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнүүдэд аудит хийж 2022 оны 05 сарын 04-ний өдөр ирүүлсэн 194 тоот албан шаардлагын дагуу зөрчлийг арилган ажиллаж байна. Тус мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтын ил тод байдал цэсэд шилэн данс хэсэгт байршуулаад байна. http://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=234 | 100% | 100% | |
| | 47 | | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | 2022 онд Худалдан авах ажиллагааны /А3/ сертифкаттай иргэдийн нөөц бүрдүүлэх сургалтыг "Худалдан авах ажиллагааны хөгжлийн төв" төрийн бус байгууллага болон "Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв" төрийн бус байгууллагуудтай хамтран 2 удаа сургалт зохион байгуулж, 44 хүн тэнцэж үнэлгээний хороонд томилогдон ажиллаж байна. Уг мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтад байршуулж нээлттэй мэдээлсэн. http://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=227&nid=27718 | 100% | 100% | |
| | 48 | | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй 15 төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, явц үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй тайланг www.dundgovi.gov.mn сайтын Ил тод байдал цэсэд Төсөл хөтөлбөр хэсэгт байршуулсан. http://www.dundgovi.gov.mn/data/main/main1670555019.pdf | 100% | 100% | |
| | 49 | | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | Дундговь аймгийн хэмжээнд мэргэжлийн байгууллагуудаас хийсэн "Цаг агаарын аюултай үзэгдлийн судалгаа", "Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлага", "Хөрсний бохирдлын судалгаа"-ны ажлын материалыг www.dundgovi.gov.mn сайтад байршуулсан. https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=779 | 100% | 100% | |
| | 50 | | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны | Хууль тогтоомжид заасан бусад төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг аймгийн сайтад байршуулахаас гадна шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж хэвшээд | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | байна. | | | |
| | 51 | | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | Төрийн архиваас үйлчилгээ авах үнэ тариф, тусгай зөвшөөрөл болон зарим үйлчилгээ авахад бүрдүүлэх шаардлагатай баримт бичгийн талаарх мэдээллийг dundgovi.gov.mn сайтын Ил тод байдал цэсийн "Үйлчилгээ авахад бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг" цэсэд байршуулж нээлттэй ил тод мэдээлсэн. http://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=778 | 100% | 100% | |
| | 52 | | 8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | Архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түгээмэл тархацтай ашигт малтмал, эрүүл мэндийн чиглэлээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, цуцалсан шийдвэрийн дэлгэрэнгүй мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтын Ил тод байдал цэсний тусгай зөвшөөрөл хэсэгт нээлттэй мэдээлж байна. http://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=667 | 100% | 100% | |
| | 53 | | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | Хууль тогтоомжийн төсөл, төрийн байгууллагаас санаачлан хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд, газрын болон зусланд амрагчдын үнийн өөрчлөлт, орон нутгийн сангийн журмын төслүүдийг www.dundgovi.gov.mn сайтын нээлттэй хэлэлцүүлэг хэсэгт тус тус байршуулж санал авсан байна. | 100% | 100% | |
| | 54 | | 8.6.2. эзэмшиж байгаа оюуны | орон нутагт эзэмшиж байгаа оюуны өмч байхгүй | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өмчийн эрхийн жагсаалт; | | | | |
| | 55 | | 8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон тус төлөвлөгөөнд оруулсан тодотгол, хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг www.dundgovi.gov.mn аймгийн нэгдсэн сайтад байршуулан ил тод байдлыг хангаж ажиллаж байна. https://dundgovi.gazar.gov.mn/?p=1870 | 100% | 100% | |
| | 56 | | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Төрийн захиргааны байгууллагын эзэмшиж буй газрын мэдээллийг www.dundgovi.gov.mn аймгийн нэгдсэн сайтын Ил тод байдал цэсэд байршуулсан. https://dundgovi.gov.mn/mn/index.php?pid=970 | 100% | 100% | |
| | 57 | | 8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | Аймагт төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 1 байгууллага байдаг бөгөөд тухайн байгууллагын мэдээллийг ил тод нээлттэй байлгах үүднээс аймгийн сайтад төрийн байгууллагууд цэсд оруулан холбогдох мэдээллүүдийг ил тод байршуулж байна. | 100% | 100% | |
| | 58 | | 8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны | Аймагт төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 1 байгууллага байдаг бөгөөд тухайн байгууллагын мэдээллийг ил тод нээлттэй байлгах үүднээс аймгийн сайтад төрийн байгууллагууд цэсд оруулан холбогдох мэдээллүүдийг ил тод байршуулж байна. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | | | | |
| | 59 | | 8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2022 онд орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой нийт 39 тогтоол гарч үүнээс 9 байгууллагын 221.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий 13 автомашиныг дуудлагаар худалдах, 6 байгууллагын ашиглалтын шаардлага хангахгүй болсон 67.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий 8 ширхэг автомашиныг актлах, 2 байгууллагын 68.7 сая төгрөгийн балансын өртөгтэй 2 ширхэг автомашиныг хэрэгцээт байгууллагад шилжүүлэх, 3 байгууллагын нийт 232.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий 6 ширхэг барилгыг үнэлгээ тогтоон худалдах, 2 байгууллагын илүүдэлтэй ашиглахгүй байгаа нийт 122.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг барилгыг балансаас балансад шилжүүлэх, 6 байгууллагын нийт 775.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий ашиглалтын шаардлага хангахгүй болсон 12 ширхэг барилгыг актлах, нийт 322.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий 438 ширхэг ашиглалтын шаардлага хангахгүй болсон машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хасах, нийт 4 байгууллагын 30 ширхэг илүүдэлтэй ашиглахгүй байгаа тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг дутагдалтай байгаа 6 байгууллагад балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлүүллээ. Мөн “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг шинэчлэн, тогтоол гарган орон нутгийн өмчийн харилцаанд мөрдөн ажиллаж байна. Орон нутгийн өмчит 25 хуулийн этгээдийн 199 түрээсийн гэрээг баталгаажуулж түрээсийн орлого 19.5 сая төгрөг, мөн орон нутгийн өмчит байгууллагын акталсан хөрөнгө, барилга, их засвараас гарсан материалыг худалдан | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | борлуулахад хяналт тавьж 47.7 сая төгрөг 2022 онд нийт орон нутгийн орлогын дансанд 67,2 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн. Мэдээллийг аймгийн сайтад тол тод байршуулсан. | | | |
| | 60 | | 8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | Төрийн болон төрийн өмчийн байгууллагуудад хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээлэл байхгүй. | Х.Б | Х.Б | |
| | 61 | | 8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлтийг www.dundgovi.gov.mn аймгийн вэб сайтын төрийн байгууллагууд цэсэд Барилга, байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт хэсэгт байршуулж нээлттэй ил тод мэдээлж байна. Холбоос линк https://dundgovi.gazar.gov.mn/?p=1871 | 100% | 100% | |
| | 62 | | 8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ; | Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар аймгийн Засаг дарга Мирайфлюорид, Адил-Оч, Тайшен девелопмент, Хуучин-Андууд, Эм Жи Би, Хан Хас трейд, Майн Ланд майнинг, Үнэн-Анд, Скайтимбер, Чинхаш, Эрдэнэ гипс, Каймекс, Таргт гөлтгөнө, Түмэн тал, Түмэн цацал, Эм Си Си Эм, Амардалай трейд, Идэрмакс, Говьшоо, Жуо Юүэ Жин Энержи Монголиа, Очир мандал, хайрхан, Хэрлэн энерго, Тайхар-Орд, Гурвансайхан, Бор-Өндөр УБҮ гэсэн нийт 25 уул уурхайн аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтын ил тод байдал цэсийн Бодлого шийдвэр хэсэгт байршуулж нээлттэй мэдээлсэн. | 100% | 100% | |
| | 63 | | 8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй | Нээллттэй өгөгдөл байхгүй | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | | | | |
| | 64 | | 8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | Хүний нөөцийн хөтөлбөрийн хүрээнд орон нутагт зайлшгүй шаардлагатай нарийн мэргэжлээр суралцаж буй оюутнуудтай орон нутагтаа ирж ажиллах гэрээ байгуулан нийт 26 суралцагчийн 59.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийг www.dundgovi.gov.mn сайтын хүний нөөц хэсэгт нээлттэй мэдээлсэн. http://www.dundgovi.gov.mn/mn/index.php?pid=654 | 100% | 100% | |
| | 65 | | 8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Аймаг орон нутгаас баримталж буй бодлого, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, орон нутагт хэрэгжүүлж буй иргэд олон нийт рүү чиглэсэн арга хэмжээ зэргийг www.dundgovi.gov.mn сайтын цаг үеийн мэдээ цэс болон Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар албан ёсны пэйжид ил тод мэдээлж байна. | 100% | 100% | |
| 7 | 66 | Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24 | 11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, | Аймагт хамааралгүй заалт | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.) | | | | |
| 8 | 67 | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01 | 15.7. Согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин суудж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно. | ХХААХҮ-н сайдын 272-р тушаалаар баталсан нормативын дагуу согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл байхаар тогтоон ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 3 сумын 7 аж ахуй нэгжид согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн эрхийг олгосон. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| | 68 | | 23.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьялах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно. | 2022 оны байдлаар нийт 28 үүнээс шинээр олгосон 7, сунгасан 21 ААН-д огтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 7 удаагийн захирамжаар ажиллах цагийн хуваарийг тогтоон ажилласан. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| УИХ-ын тогтоол | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 69 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-06-09 Дугаар 2017 №46 | 1.10.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг хөгжүүлэх төвүүдийг аймаг, дүүрэгт байгуулах; | Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хамтарсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан суманд баригдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгыг хүлээн авах улсын комиссыг Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2022 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс томилох тухай" А/57 дугаар тушаалаар байгуулж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ажиллав. Комиссын бүрэлдэхүүнд захиалагч талаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, хөрөнгө оруулагч талаас Азийн хөгжлийн банкны төслийн нэгж, зураг төсөл зохиогч “ЭМ ЭС ЭЛ” ХХК-ны төлөөлөл, гүйцэтгэгч талаас Ц.Ганзориг захиралтай “Хөх хайрхан трейд" ХХК-ны төлөөлөл, ашиглагч талаас ХХҮГ болон аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ХБ иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага зэрэг барилга хүлээж авах комиссын бүрэлдэхүүн барилгын гүйцэтгэлтэй танилцаж хугацаатай үүрэг даалгаврын биелэлтээр улсын комисс хүлээн авлаа.<br><br>Хавсралт : 1 зураг | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| 10 | 70 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 | 1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй | Аймгийн хэмжээнд коронавирусын халдварын шинэ тохиолдол 2022 онд 3352 бүртгэгдсэн ба үүнээс 2 нь буюу 0.07% нь хүүхэд байна. ЭМХТ, ХӨСҮТ, НЭМҮТ-үүд хамтран коронавируст халдвар болон бусад халдварт өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан сургалтад ЭМГ-ын 2 мэргэжилтэн, ЕБС-ийн 11 эмч, Хүүхдийн Цэцэрлэгийн 22 эмчийг тус тус хамруулж, цар тахлын улмаас эрсдэлт нөхцөлд орсон хүүхэд, гэр бүлд хариу үйлчилгээ үзүүлэх мэдлэг, чадварыг сайжрууллаа. Дундговь аймгийн хүүхэд, гэр бүлийн мэдээллийн санд нийт 1606 хүүхэд бүртгэгдсэнээс эрсдэлгүй 1376, бага эрсдэлтэй 13, дунд эрсдэлтэй 23, өндөр эрсдэлтэй 194 хүүхэд тус тус бүртгэгдсэн байна. “Хүүхэд эрхэм хэрэглэгч” аян, “Хамтдаа” хөгжлийн хөтөлбөр, “Мэдлэгээ хүчирхэгжүүлье”, “Охидод үлгэрлэе” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд нийт эрсдэлт нөхцөлд амьдарч буй бага, дунд, өндөр эрсдэлтэй 230 | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2021 №67 | хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:) | хүүхдүүдийн 215 хүүхэд буюу 93.5 хувьд хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ үзүүллээ. Тус үйл ажиллагаануудад 3,666,000 төгрөгийн төсөв зарцууллаа. | | | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | | |
| 11 | 71 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | 3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр "Гэрэлтдэг ертөнц" ТББ, "Төгөлдөршил" хувь хүний хөгжлийн төв ТББ, “Монголын хүүхэд, гэр бүл судлалын академи”, Дүүрэн билэг НҮТББ, Илтгэгч Н.Ганбилэг нартай хамтран ажиллах ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, нийт 6 төрлийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Гэрээний биелэлт 100%-тай байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 8 чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 10213 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан. Хамтарсан багийн дарга, нарийн бичиг нарт NAMS програмд бүртгэх цахим сургалт 1 удаа, танхимын сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт 15 сумын хамтарсан багийн 158 гишүүнийг хамруулж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллалаа. 2022 онд гэр бүлийн хүчирхийллийн 42 кейс бүртгэгдэж, кейс шийдвэрлэлт 94 хувьтай байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар 71.0 сая төгрөгний өртөг бүхийн төслийн саналыг боловсруулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 30,000,000 төгрөгний төсвийг шийдвэрлүүллээ. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах. | | | | |
| 12 | 72 | Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ | 1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх; | Аймгийн ахмадын ордоны барилгыг 2022 оны 12 сарын 30-нд улсын комисс хүлээн авч ашиглалтанд оруулав. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 80,0 сая төгрөгний зардал шийдсэн. 15 сум ахмадын байртай бөгөөд урсгал зардлыг сумдууд өөрсдөө хариуцаж байна. Аймгийн Засаг дарга Ахмадын спортын наадмын үйл ажиллагаанд 3,0 сая/төг, Ахмадад ээлтэй байгууллага, баг шалгаруулж 1,000,0 сая/төг, Сумдын Ахмадын хороодын ажлын үр дүнгийн урамшуулалд 3385,0 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг тус тус үзүүлсэн.<br><br>Хавсралт : 2 зураг | 100% | 100% | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 13 | 73 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | 107 төрийн байгууллага гадна хаягаа болон өрөөний хаягийг, 236 албан хаагч нэрийн хуудас, 12 байгууллага мэдээллийн самбараа монгол бичгээр үйлдээд байна. Энэ нь нийт төрийн байгууллагын 63.1 хувь, сумдын 93,3 хувь нь монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Үндэсний бичиг соёл-Номын өдөр” арга хэмжээний хүрээнд Төрийн албан хаагчид болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Цэвэр сайхан бичигтэн”, “Мөнх тэнгэрийн бичиг”, "Миний монгол бичиг-2022" сэдэвт бичвэрийн уралдаан, “Тэргүүний хурдан уншигч” уралдаан, “Монгол бичгийг моод болгоё” сэдэвт хичээнгүй цэвэр бичих аян, “Хос бичиг”-ийн үзэсгэлэн, Уран бичвэрийн клубын хүүхдүүдийн үзэсгэлэн, “Тэнгэр заяат хүмүүн бичиг" сэдэвт үндэсний бичгийн номын цахим үзэсгэлэн зэрэг аймаг, сумдын хэмжээнд 8 арга хэмжээг зохион байгуулж, 816 иргэнийг оролцуулан, тэдний бүтээлээр үзэсгэлэн гаргаж, тус үйл ажиллагааны бичлэгийг цахимаар сурталчлан, 5000 гаруй хандалт авсан. Мөн "Үндэсний бичиг" олон талт арга хэмжээний хүрээнд Хэлний бодлогын салбар зөвлөлийн даргаар батлуулсан удирдамжийн дагуу 18 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан нь төрийн албан хаагчид, иргэд, хүүхдүүдийн | 70% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эх хэлээрээ зөв сайхан бичих, унших чадварыг нэмэгдүүлсэн, өв тээгч нарыг илрүүлэн урамшуулсан арга хэмжээ болов. Тус арга хэмжээнд 1438 суралцагч, багш, иргэд, төрийн албан хаагч үндэсний бичгийн мэдлэг, ур чадвараа сорин оролцлоо. Уг арга хэмжээнд аймгийн Засаг даргаас 850,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.<br><br>Хавсралт : 11 зураг | | | |
| 14 | 74 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих | Ерөнхий боловсролын сургуулиас 150 метрийн радиуст байрлах хүнсний худалдааны газар 27 үүнээс согтууруулах ундаа худалдан борлуулж буй 22 аж ахуйн нэгж/, түргэн үйлчилгээний 1 газар байна. Худалдаа үйлчилгээний газруудыг ангилбал супермаркет-7, минитаркет-3, хүнсний дэлгүүр-17, худалдааны төв-1 мухлаг-1 байна. Ерөнхий боловсролын сургуулиас 150 метрийн радиуст байрлах хүнсний худалдааны газруудад хяналт шалгалтаар хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горим, агуулах, бүртгэл хөтөлгөө, тээврийн хэрэгсэл, хаяг шошго дотоод хяналт, бүтээгдэхүүний гарал үүслийн бичигтэй холбоотой нийт 48 дутагдал илрүүлж зөрчлийг 100 хувь арилгуулж ажилласан. 2022 онд хоолны болон бусад зүйлээс хордлого авсан тохиолдолд бүртгэгдээгүй. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| 15 | 75 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг | "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Дундговио ногооруулъя” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХурлын тогтоолоор 2022 онд 240.0 сая төгрөг батлуулсан. Хөтөлбөрөөс Сайнцагаан сумын "Аривжих төгөл"-д ногоон байгууламжийн усалгаа, арчилгаанд зориулж гүн өрмийн худаг 1, мод тарих, хашаа хамгаалалт барих ажилд 8 суманд дэмжлэг, сургалт, зөвлөгөөн, тарьц, суулгац, ойн аж ахуй болон хөдөө аж ахуй газар тариалангийн багаж тоног төхөөрөмжийн үзэсгэлэн худалдаа, аймгийн 80 жилийн ойг угтаж цэнгэлдэх хүрээлэнгийн эргэн тойрон, авто зам дагуу далд үндэсний системтэй мод, зүлэг тарих, ногоон байгууламжийн усалгаа арчилгааны шатахууны зардал, усны төлбөрт нийт 118967200 төгрөгийг зарцуулав. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 122884 мод сөөг тарьж ногоон | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах | байгууламжийн хэмжээ өмнөх оноос 51 хувиар нэмэгдсэн. <br><br> Хавсралт : 1 файл | | | |
| | 76 | | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, “Дундговио ногооруулъя” хүрээнд 2022 оны хаврын "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-өөр төв цэнгэлдэх хүрээлэнг тохижуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шинэ төгөл байгуулах зорилгоор 1,8 га талбайд 5 төрлийн 9600, “Аривжих төгөл”-д 4100, Сайхан-Овоо сум 7 га талбайд шинээр байгуулсан цэцэрлэгт хүрээлэнд 11000 мод сөөг тарьж шинээр 3 байршилд цэцэрлэгт хүрээлэн байгуулж 25112 мод, сөөг тарьж ургууллаа. Аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтан 7 дугаар сард нийтийн эзэмшлийн талбайд 8 төрлийн 7425 ш хайлаас, паркийн сарнай, шар навчит хайлаас, тэсмэг, гандигар, улиас, агч, голт бор, заг зэрэг 10 төрлийн 7500 ширхэг модыг бортгонд үржүүлэн нийтийн эзэмшлийн талбайд тарьж ургууллаа. “Мод тарих үндэсний өдөр”-өөр 5, 10 дугаар сарuудад аймгийн хэмжээнд 122884 мод сөөг тарьж ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оноос 51 хувиар нэмэгдсэн. Дэд хөтөлбөрийн хүрээнд "Ногоон хөгжлийн зөвлөгөөн" "Дундговио ногооруулъя" танхимын сургалт, өвлийн нарлаг хүлэмжид нарийн ногоо тарих, сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрын талбайд үрээр болон мөчрөөр тарих үзүүлэх сургалтад нийт 193, Өмнөговь аймгийн Агропаркийн хүлэмжний аж ахуй, алимны төгөлд туршлага судлах чиглэлээр 36, нийт 229 иргэнийг хамрууллаа. Мөн Говь-Угтаал сумын “Малчдын зөвлөгөөн”, Өлзийт сумын Буянт багийн өдөрлөг, Сайнцагаан сумын ахмадын холбоо, Онцгой байдлын газар, Говийн-Ирээдүй цогцолбор сургууль 22 аж ахуйн нэгжийн 424 албан хаагчид, | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | малчдад сургалт хийж иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлж мод тарих ажлыг сурталчлан түгээж, биечлэн оролцож ажиллалаа.<br><br>Хавсралт : 8 зураг | | | |
| | 77 | | 1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах | Мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Дэрэн, Өндөршил, Сайнцагаан, Сайхан-Овоо суманд тус бүр 1 худаг нийт 4 гүн өрмийн худгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гаргасан. “Ногоон Ази” ТББ-аас Гу-Янь хотын төгөлийн 4, 5 дугаар талбайд 20000 дуслын усалгааны систем нэмж суурилуулав. Ингэснээр тус 100 га талбайд 80000 дуслын усалгааны систем нэвтрүүлж хүний хөдөлмөрийг хөнгөвчилж модны ургалтын хувийг нэмэгдүүллээ. Өлзийт сумын Буянт багийн нутаг “Жавхлант хайрхан” хэмээх газарт байрлах “Хөтөл ус”-ны энгийн уурхайн худгийг түшиглэн Улсын төсвийн хөрөнгөөр хөв цөөрөм байгууллаа. Зураг төсвийн дагуу 1000 мм голчтой 3 ширхэг кольцо суулган, 120 мм диаметртэй 42 метрийн урт ус дамжуулах хоолой суурилуулж, 4 м3 эзлэхүүнтэй усан сан хийж гадаргын усны хуримтлал үүсгэснээр ногоон байгууламжийн усалгаанд ашиглах боломж бүрдсэн.<br><br>Хавсралт : 5 зураг | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| | 78 | | 1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон | "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр", "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн", "Дундговио ногооруулъя хөтөлбөр"-ийн хүрээнд “Ногоон хөгжлийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 05, 10 дугаар саруудад тарьц, суулгац, ойн аж ахуй болон хөдөө аж ахуй газар тариалангийн багаж тоног төхөөрөмжийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 24 иргэн, 1 аж ахуйн нэгжид 87 нэр төрлийн багаж тоног, төхөөрөмжийг нийлүүлж ажиллалаа. Аймгийн хэмжээнд ойн зурвас байгуулахаар 750.91 га, мод үржүүлгийн газар байгуулах зориулалтаар 104.33 га, нийт 855.24 га газрыг 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулж 122884 ширхэг мод, сөөг тарьж ургууллаа. | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжүүлэх | Хавсралт : 8 зураг | | | |
| | 79 | | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг идэвхтэй өрнүүлэх үүднээс улсын чанартай авто зам дагуу мод тарьсан 53 төрийн байгууллага, 19 аж ахуйн нэгж байгууллагын дунд “Манай төгөл”, Шилдэг ногоон байгууламжтай сум, аж ахуйн нэгж, айл өрх шалгаруулах болзолт уралдааныг тус тус зарлан идэвх санаачилгатай оролцохыг уриалж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагат сургалт, мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласны үр дүнд байгууллага бүр хариуцсан талбайнхаа модны арчилгаа, усалгааг хувиарын дагуу хийж авто зам хамгаалсан зурвасыг 81.0 хувьтай ургуулсан. Мөн “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, “Зөв мод-Зөв арчилгаа” аяны хүрээнд 15 сумын ерөнхий боловсролын сургуулийн 12 эко клубуудын 122 сурагчид оролцсон “Бүтээе-хамгаалъя” чуулганыг зохион байгуулж оролцсон 122 сурагчдад “Тэрбум мод хөдөлгөөн”-ий танилцуулга хийж, тасалгааны болон мандлын цэцгийн үрсэлгээний үзэсгэлэн гаргаж, мод, цэцэг, зүлэг тарих аргачлал, байгаль эх дэлхий, амьтан, ургамал, ногоон байгууламжаа хайрлан хамгаалж өсгөн нэмэгдүүлэх амьдрах орчноо сайжруулснаар гарах ач холбогдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.<br><br>Хавсралт : 6 зураг | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| 16 | 80 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 | 1.3. Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос хавдрын эмнэлэг, донтох өвчнийг эмчлэх төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг байгуулах, архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлд | Тус аймгийн хэмжээнд 2022 онд архи согтууруулах ундаанд ногдуулах албан татварт нийт 82,864,0 төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрлүүлсэн. Зарцуулах эрх нь орон нутагт байхгүй. | 100% | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зарцуулах; | | | | |
| | 81 | | 1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох; | Тус аймгийн нутаг дэвсгэрт нийтийг хамарсан арга хэмжээ, баяр ёслолын өдрүүдэд Цагдаагийн газраас өргөтгөсөн эргүүл шалгалт хийн ажилласан ба нийтийг хамарсан 46 арга хэмжээний хамгаалалтад цагдаагийн 472 алба хаагч, 86 тээврийн хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж арга хэмжээ болж байгаа газрын орчимд эргүүл шалгалтыг зохион байгуулж Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр агуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэсний улмаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдол бүртгэгдээгүй байна. | 100% | 70% | |
| | 82 | | 1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах; | Спортыг орон нутагт олон төрлөөр нь хөгжүүлэх, тамирчид, багш дасгалжуулагчдыг чадавхжуулах зорилгоор спортын 17 холбоо, 8 клубтэй хамтран, Бүх ард түмний XV наадам, Үндэсний спортын VII наадмын анхан шатны тэмцээн, улсын аварга шалгаруулах тэмцээн 6, улсын бүсийн аварга шалгаруулах тэмцээн 2, аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээнүүдийг спортын 15 төрлөөр 80 гаруй уралдаан, тэмцээнийг зохион байгуулж, нийт 28500 тамирчдыг оролцуулсан. Өсвөр үеийн шигшээ багийг спортын 15 төрлөөр байгуулан, нийт 156 тамирчны бэлтгэл сургуулилалтыг нь хангаж, ХААН банкны 76 сая төгрөгийн санхүүжилтээр 3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулсан. Мөн Үндэсний сурын харвааны шинэ тайлбайг ашиглалтанд оруулж, 15 сумын биеийн тамирын багш нарыг спортын хэрэглэгдэхүүнээр хангаж, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд хөрөнгө оруулалт хийсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан “Илүүдэл жингүй-Эртэч монгол" аяны хүрээнд нийт 42268 иргэнийг нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэх орчин нөхцөлийг аймгийн 15 сумын 18 заал, 5 клуб, 9 танхим, 43 байгууллага дээр бүрдүүлж ажилласан. Энэ онд зохион байгуулагдсан Улсын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнүүдээс алт-40, мөнгө-54, хүрэл-48, нийт 142 медаль хүртэж, Буриад сурын улсын мэргэн-1, Шагайн харвааны улсын мэргэн-1 төрж, 66 хүн спортын цол | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | авсан бөгөөд аймгийн Засаг даргын 2022 оны А/88 дугаар захирамжийн дагуу амжилт гаргасан баг тамирчид, багш дасгалжуулагч нийт 150 хүнд 25.7 сая төгрөгийн урамшуулал олгосон. Мөн Биеийн тамир, спортын газар, спорт холбоодуудын үйл ажиллагаанд болон тамирчдад аймгийн орон нутгийн хөгжлийн сан, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 121,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. | | | |
| | 83 | | 2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай. | Аймгийн Засаг даргаас сар бүрийн 1, 15-ний өдрүүдэд “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай” захирамж гарган хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллагууд хяналт тавин ажиллаж байна. Цагдаагийн газрын криминолги судалгааны баг 14 хоног тутам гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүгнэлт хийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдсэн газарт эргүүлийн чиглэлийн тоог нэмэгдүүлж 19:00 цагаас 00:00 цагийн хооронд явган эргүүл, мөн 7 хоног бүрийн 5 дахь өдрүүдэд өргөтгөсөн эргүүлийг томилон ажиллуулж байна. Аймгийн засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн А/95 дугаартай захирамжаар мэргэжилтний баг томилж “Говийн хийморь” АА бүлэгтэй хамтран иргэдийг сайн дурын үндсэн дээр архинд донтох өвчнийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагааг явуулж байна. Архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг болон түүгээр үйлчилдэг аж ахуй нэгжүүд болон аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран өндөр хатуулагтай архи согтуурулах ундааны хэрэглээг бууруулах болон зохистой хэрэглэх чиглэлээр “Архигүй амьдралыг цогцлооё 1, 2”, “Намайг алгас” нөлөөллийн аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж цаашид архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах чиглэлээр ажиллаж байна. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| 17 | 84 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар | 2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг | Аймгийн 22 цэцэрлэг, 19 сургууль нийт 41 сургалтын байгууллага болон Боловсрол, шинжлэх ухааны газар 2022 оны 08 сарын 28-ны өдөр Чингисийн эш хөргийг хүлээн авч 2022 оны 09 сарын 01-ны өдөр хүндэтгэлийн буландаа залсан. Мөн төрийн байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан. Мөн "Монгол бахархлын өдөр"-ийг тохиолдуулан аймгийн ИТХ-аас санаачлан 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр "Монгол бахархал" арга хэмжээг зохион | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022_159 | дээдлэн залсугай. | байгуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга С.Од-Эрдэнэ нээж, Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай зарлиг гарсан тухай танилцуулан, төрийн байгууллага, Монгол хүн, айл өрх бүр Чингис хааны эш хөргийг залахыг уриалж, аймгийн 15 сумын удирдлагуудад Чингис хааны эш хөргийг гардуулан өглөө. Дундговь аймгийн Соёл, урлагийн газар нь Эзэн Богд Чингис хааны эш хөргийг залж, билиг сургаалыг алтан шармалаар бичиж эрхэмлэн дээдэллээ.<br><br>Хавсралт : 4 зураг | | | |
| | 85 | | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | "Монгол бахархлын өдөр"-ийг тохиолдуулан аймгийн ИТХ-аас санаачлан 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр "Монгол бахархал" арга хэмжээг зохион байгуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга С.Од-Эрдэнэ нээж, Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай зарлиг гарсан тухай танилцуулан, төрийн байгууллага, Монгол хүн, айл өрх бүр Чингис хааны эш хөргийг залахыг уриалж, аймгийн 15 сумын удирдлагуудад Чингис хааны эш хөргийг гардуулан өглөө. Монгол үндэстний үнэт зүйл" бахархлыг алдаршуулах хүрээнд "Чингисийн эш хөрөг" залах, сургаалийг дээдлэх талаар төрийн байгууллага, бүх шатны сургалтын байгууллагууд, айл өрх бүрийг уриалсан цахим сурталчилгааг хийлээ.<br><br>Хавсралт : 1 зураг | 100% | 100% | |
| | 86 | | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо | "Монгол бахархлын өдөр"-ийг тохиолдуулан аймгийн ИТХ-аас санаачлан 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр "Монгол бахархал" арга хэмжээг зохион байгуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга С.Од-Эрдэнэ нээж, Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай зарлиг гарсан тухай танилцуулан, төрийн байгууллага, Монгол хүн, айл өрх бүр Чингис хааны эш хөргийг | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өвлүүлэн үлдээж, эв ээ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | залахыг уриалж, аймгийн 15 сумын удирдлагуудад Чингис хааны эш хөргийг гардуулан өглөө. Монгол үндэстний үнэт зүйл” бахархлыг алдаршуулах хүрээнд “Чингисийн эш хөрөг” залах, сургаалийг дээдлэх талаар төрийн байгууллага, бүх шатны сургалтын байгууллагууд, айл өрх бүрийг уриалсан цахим сурталчилгааг хийлээ. | | | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | |
| 18 | 87 | Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09 | 1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх, | Аймгийн хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон сургууль, цэцэрлэг, эмнэлэг, орон сууцны барилгыг буулгаж, дахин төлөвлөх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна. 2022 онд Сайнцагаан сумын Хүмүүнлэг 3 дугаар сургуулийг буулгаж шинээр 660 суудалтай сургууль спорт заалны барилгын ажлыг “Си Эйч Би Жи Констракшн” ХХК 9,8 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 9 дүгээр сарын байдлаар буулгалтын ажлыг бүрэн хийсэн. Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж шинээр 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг “Энх баялаг констракшн” ХХК 2,710 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан, буулгалтын ажлыг хийсэн. Мөн 1 үйлчилгээний барилгыг буулган 24 орон сууц төлөвлөн барилгын явц 95 хувьтай байна.<br><br>Хавсралт : 1 зураг | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| | 88 | | 3. Газар хөдлөлтийн аюул, гамшиггай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тоггмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооодог байх, | Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу орон нутгийн хүн амд гамшгаас хамгаалах тухай мэдлэг олгох, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг нийт 308 удаа, 484 цагийн сургалтыг зохион байгуулж 10685 иргэнийг хамруулсан нь орон нутгийн нийт хүн амын 22,7 хувийг эзэлж байна.<br><br>Хавсралт : 7 зураг | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| 19 | 89 | Нийслэлийн агаар, орчны | 3.1. Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн | Дундговь аймгийн хог хаягдлын менежментийн сайжруулах хөтөлбөрийг Аймгийн иргэдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны | 100% | 70% | Бодит үр дүнг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бохирдлын тухай 2017-01-10 Дугаар 2017_03/03 | орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | 01 сарын 04-ны өдрийн 12 дугаар тогтоолоор 2018-2023 хүртэлх хугацаагаар баталсан ба 2022 оны төлөвлөгөөнд ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх, дахивар хог хаягдлыг үйлдвэрт нийлүүлэх, хогийн цэгийн талбайг шууж багасгах, бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгулах зэрэг ажлуудыг тусган 98 хувьтай хэрэгжүүлсэн. | | | нэмэгдүүлэх |
| 20 | 90 | Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40 | 2.4. Томоохон голууд дээр усыг хуримтлуулан урсацын тохируулга хийх. усан сан байгуулах, нийт нутгийн хэмжээнд хур тундасны усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэн цөөрөм барих ажлыг эрчимжүүлэх замаар усны нөөцийгш нэмэгдүүлж,и хүн ам болон эдийн засгийн салбаруудыг баталгаатай, хүрэлцээтэй усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх | Орхон голоос эх авч урсдаг Онги голын урсацыг нэмэгдүүлэн Улаан нуурыг тэтгэж, улмаар говийн бүсийн сум суурингийн хүн ам, бэлчээр, хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийн найдвартай эх үүсвэр бий болгох, эрчим хүч үйлдвэрлэх зорилготой “Орхон-Онги” эко төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг “Хайдродизайн прожект” ХХК, “Престиж инженеринг” ХХК, “Монхидро констракшн” ХХК, “Жемр” ХХК-иуд хамтран гүйцэтгэсэн. Өлзийт, Баянжаргалан сумдад хөв цөөрөм байгуулахаар хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн. "Цэнхэр алт-Ногоон хэрэм" монголын үндэсний усны ассоциаци Сайхан-Овоо сумын Онгийн хийдээс доош, хавцлаас уруудан гарах хэсэгт ус хуримтлуулах зорилгоор 13м -ийн өндөртэй боомтоос хэрэглээний усыг Цамхагт ус гаргуураар гаргахаар, үерийн үеийн усыг боомтын хажуу талын салаа голруу сувгаар урсгахаар төлөвлөсөн. Онги гол дагуу 5,5 мян.га-д мод тарихаар төлөвлөн ажиллаж байна. Өлзийт сумын Буянт багийн нутаг “Жавхлант хайрхан” хэмээх газарт байрлах “Хөтөл ус”-ны энгийн уурхайн худгийг түшиглэн Улсын төсвийн хөрөнгөөр хөв цөөрөм байгууллаа. Зураг төсвийн дагуу 1000 мм голчтой 3 ширхэг кольцо суулган, 120 мм диаметртэй 42 метрийн урт ус дамжуулах хоолой суурилуулж, 4 м3 эзлэхүүнтэй усан сан хийж гүйцэтгэлээ. Мөн Юнител группийн хөрөнгө оруулалтаар "Дэлгэрхангай уул", "Их газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газруудад зэрлэг амьтдад зориулсан хөв цөөрмийг байгуулав. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| | 91 | | 2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи | Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг Азийн Хөгжлийн Банк 8.875.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "Сайн констракшн" ХХК-р гүйцэтгүүлэн хүлээн авсан. Сайхан-овоо сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлыг Улсын төсөв, 1,22 тэрбум төгрөгийн | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх | санхүүжилтээр "Алтайн үндэс констракшн" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа ба ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна. “Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх” болзолт уралдааныг 3 сарын хугацаанд зохион байгуулсан. Аяны хүрээнд “Нүхэн жорлон, бохирын цооногийн халдваргүйтгэл, хортон шавьж устгах ажлыг нийт 11 сумын гэр хорооллын айл өрх, аж ахун нэгж, байгууллагын 4670 нүхэн жорлон бохирын цооногт хийсэн. Ариун цэврийн байгууламжийн шийдлүүд, сайжруулсан ариун цэврийн байгууламж зэрэг сэдвүүдээр 19 удаагийн сургалт зохион байгуулж 427 хүнд хамрагдаж, 4 төрлийн боршурыг 516 хүнд тараасан. “Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай айл, өрх” болзолт уралдаанд эрүүл мэндийн байгууллагуудаас шалгаран ирсэн 13 айлын материал дээр шалгаруулт хийж 3 байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Нийт 840,000 төгрөг зарцуулсан.<br><br>Хавсралт : 2 зураг | | | |
| | 92 | | 2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих | “Онгийн нууц”, “Онги энерги”, “Говь суварга” жуулчны баазууд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулж цэвэршүүлсэн саарал усыг ногоон байгууламжийн усалгаанд дахин ашиглаж байна. Баяжуулах үйлдвэртэй Гурвансайхан сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэс силвер ресурс” ХХК нь 30 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжтай. Үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологи нэвтрүүлж 97% -иар цэвэршүүлэн дахин ашиглаж байна. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| | 93 | | 2.11. Хо, суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийн найдвартай ажиллагааг хангах | Үерийн хамгаалалтын далан сувгийг бүрэн дуусгахад 5,1 тэрбум төгрөг нэмж шаардагдаж байгаа талаар 2022 оны улсын төсвийн программад шивэн Барилга, хот байгуулалтын яамруу хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр хүсэлт хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй ба 2023 оны улсын төсвийн төсөлд хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр саналаа хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс | 30% | 30% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 94 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03 | 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, “Зөв мод-Зөв арчилгаа” аяны хүрээнд 15 сумын ерөнхий боловсролын сургуулийн 12 эко клубуудын 122 сурагчид оролцсон “Бүтээе-хамгаалъя” чуулганыг зохион байгуулсан. Үзэсгэлэнд оролцсон 122 сурагчид Тэрбум мод хөдөлгөөний танилцуулга хийж, тасалгааны болон мандлын цэцгийн үрсэлгээний үзэсгэлэн гаргаж, мод, цэцэг, зүлэг тарих аргачлалын талаар сургалт мэдээлэл өглөө. Дэд хөтөлбөрийн хүрээнд "Ногоон хөгжлийн зөвлөгөөн" "Дундговио ногооруулъя" танхимын сургалт, өвлийн нарлаг хүлэмжид нарийн ногоо тарих, сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрын талбайд үрээр болон мөчрөөр тарих үзүүлэх сургалтад нийт 193, Өмнөговь аймгийн Агропаркийн хүлэмжний аж ахуй, алимны төгөлд туршлага судлах чиглэлээр 36, нийт 229 иргэнийг хамрууллаа. Мөн Говь-Угтаал сумын “Малчдын зөвлөгөөн”, Өлзийт сумын Буянт багийн өдөрлөг, Сайнцагаан сумын ахмадын холбоо, Онцгой байдлын газар, Говийн-Ирээдүй цогцолбор сургууль 22 аж ахуйн нэгжийн 424 албан хаагчид, малчдад сургалт хийж иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлж мод тарих ажлыг сурталчлан түгээж, биечлэн оролцож ажиллалаа.<br><br>Хавсралт : 8 зураг | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| 22 | 95 | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204 | 3. Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээс бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг | Татан төвлөрүүлсэн нийт 21 автомашинаас 5 автомашиныг зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байгууллагуудад шилжүүлэхээр, 16 автомашинд үнэлгээ тогтоон дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн. Үүнээс 1 автомашинд үнэлгээ тогтоон АИТХ-ын шийдвэрээр дуудлагын худалдаагаар худалдаж, 25.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн хөрөнгө худалдсаны орлогын дансанд 100 хувь төвлөрүүлээд байна. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | | | | |
| 23 | 96 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 Дугаар 2022_314 | 2. “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”-ийг 1 дүгээр хавсралт, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих үүднээс Ардын зан үйл-Амьдрах арга ухаан хөтөлбөрт сургалтыг Хөөмий, Морин хуур, Ардын Бүжиг, Үндэсний хөгжим, Уртын дуу, “Монгол ахуй зан заншлаас суралцах нь”, ”Зоос ширээ” урлал, “Монгол гутал урлал”, “Зүү ороох”, Цагаан алтаар урлахуй”, ноосоор бүтээл хийх гэсэн 10 чиглэлээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулж 578 иргэн хамрагдсан. "Гар урлалын бүтээл-2022" үзэсгэлэнг “Дундговьд үйлдвэрлэв” төвд зохион байгуулж, тус үзэсгэлэнд 4 сумын 20 гаруй урчуудын 190 гаруй бүтээлийг дэлгэн үзүүллээ. Үзэсгэлэнд оролцсон урчуудыг монголын уламжлалт модон эдлэл, арьс шир, Халх хувцас, эсгий, уран хатгамал гэсэн 5 төрлөөр шалгаруулан, 15 өвлөн тээгчийг шагнаж урамшуулсан. Шагналын зардалд 3 сая төгрөг зарцуулсан. “Нүүдэлчин Монгол-2022” наадмаар 19 гар урчуудын 7 ай савын төрлийн бүтээлийн үзэсгэлэн, “Адууны өв соёлтой холбогдолтой эд хэрэглэл”, “Гар урлалын бүтээл-2022” үзэсгэлэн, худалдаа 7 сумын 33 гар урчуудын 228 бүтээлээр тус тус зохион байгуулагдлаа. Тайлант онд үзэсгэлэн худалдаанд нийт 107 гар урчууд оролцон, бүтээгдэхүүний 110.200.000 төгрөгийн орлого олсон байна.<br><br>Хавсралт : 10 зураг | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | | | | |
| 24 | 97 | Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402 | 1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | 2022 онд цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг батлаагүй болно. | 100% | Х.Б | |
| | 98 | | 1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад | Тус аймгийн Сайнцагаан сумын 7 дугаар багт баригдах 240 айлын “Мандал хотхон”-ы орон сууцны барилгын 1 дүгээр давхарт үйлчилгээтэй байхаар төлөвлөсөн бөгөөд тус давхарт цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулах норм нормативыг ханган төлөвлөгдсөн. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | | | | |
| | 99 | | 2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн | Тус аймгийн Сайнцагаан сумын 7 дугаар багт 720 айлын “Түмний хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт орон сууцны барилгын 1 дүгээр давхарт цэцэрлэгийн барилгын холбогдох норм, дүрэм, стандартын шаардлага хангасан түрээслэх, худалдан авах, тус чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой талбай төлөвлүүлэхээр тусгаж, батлуулсан. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | | | | |
| | 100 | | 3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | 2022 онд Луус, Хулд, Өнөдөршил, Баянжаргалан сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан бөгөөд ерөнхий төлөвлөгөөнд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг тусгуулсан. Хулд сумын төвийн батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлын зураг төслийг боловсруулж байна. | 100% | 70% | |
| | 101 | | 4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Орон нутагт хувийн өмчийн түрээслэх, худалдах цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байхгүй учраас шийдвэр гараагүй | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | 102 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419 | 3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./ | Аймгийн Засаг даргын 2022 оны А/412 дугаар захирамжаар аймгийн Хот, хөдөөгийн сэргэлтийн дэд ажлын хэсгийг байгуулаад байна. Ажлын хэсэг 2023-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан ба аймгийн 2023 оны төсөвт үйл ажиллагаанд шаардагдах төсөв болох 300 сая төгрөгийг батлуулсан. | 100% | 70% | |
| | 103 | | 4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор | Аймгийн Засаг даргын 2022 оны А/412 дугаар захирамжаар аймгийн Хот, хөдөөгийн сэргэлтийн дэд ажлын хэсгийг байгуулаад байна. Ажлын хэсэг 2023-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан ба аймгийн | 100% | 0% | Үнэн Бодит үр дүнг нэмэгдүү |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | 2023 оны төсөвт үйл ажиллагаанд шаардагдах төсөв болох 300 сая төгрөгийг батлуулсан. Мөн аймгийн хүн амыг 10 хувиар нэмэгдүүлэх зорилгоор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар нээлттэй аймаг хөтөлбөр боловсруулан батлуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | | | лж шуурхай ажиллах |
| 26 | 104 | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448 | 1.12. . 1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн | 1.12 Орон нутгийн төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 10-30 хувиар нэмэгдүүлэн олгох асуудлыг Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2023 оны төсөвт 885.3 сая төгрөгийг төсөвлөж Аймгийн засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/17 дугаар захирамжаар шийдвэрлэв. 1.13орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллаж байна. 1.14.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд ААН-ийн 309.5 сая төгрөгийн хандивыг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулсан. 1.15 нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллана. 1.16.Нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэх талаар | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Засаг дарга нарт; 1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд | холбогдох байгууллагууд төлөвлөлтөдөө тусгасан. 1.17. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар аймгийн 2023 оын төсөвт Азийн хөгжлийн банкны зээлийн үндсэн төлбөрт 461.2 сая төгрөг, хүүгийн төлбөрт 1,479.3 сая төгрөг төлөхөөр батлуулж хуваарийн дагуу төлөлт хийнэ. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| | 105 | | 2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан | 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулж байна. 2.2.2022 оны Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтанд төлөвлөсөн болно. 2.3. 2022 оны УТХО-аар 12 өсөл арга хэмжээ эрх шилжин ирснээс 10 төсөл арга хэмжээний санхүүжилтийг журмын дагуу олгож хугацаандаа гүйцэтгэж амжаагүй 2 төсөл арга хэмжээ 2023 онд санхүүжнэ. 2022 оны ОНХС-ын 32 төсөл арга хэмжээ батлагдсанаас 25 төсөл арга хэмжээ журмын дагуу санхүүжилт олгогдож 7 төсөл арга хэмжээ 2023 онд санхүүжихээр төсөвт тусгагдсан. 2.4 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхээр Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. 2.5 Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Тус системээр 10 төсөл арга хэмжээнийй 15 удаагийн санхүүжилтыг олгоод байна. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS- www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах. | | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 27 | 106 | 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар | II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах | Аймгийн удирдлагууд болон албаны холбогдох хүмүүс 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Соёлын яамнаас томилогдсон ажлын хэсэгтэй Дундговь аймгийн Сайнцагаан суманд баригдаж буй Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга, Цагаандэлгэр суманд баригдаж буй Соёлын төвийн барилгын ажлын явц цаашид хэрхэн шийдвэрлэх талаар уулзалт хийсэн боловч тодорхой үр дүнд хүрч шийдэл гараагүй.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид | 30% | 30% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021_19 | арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | хэрэгжих | | | |
| 28 | 107 | 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14 | XIY.7.4. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад байнгын хяналт тавьж, үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Аймгийн хэмжээнд хүнсний худалдаан дахь гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулт тогвортой байна. Хүнсний худалдаа эхрлэгч аж ахуйн нэгжийн нөөцөд мах-104 тн, төмс -44,4 тн, хүнсний ногоо -18,3 тн байна. Махны үнийг өмнөх сартай харьцуулахад дунджаар хонины мах 500 төг, адууны мах 250 төгтөгөөр тус тус нэмэгдсэн бол ямааны мах 1500 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| 29 | 108 | 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24 | XIY.8.3. Хот, суурин газруудын хөгжлийн чиг хандлагыг харгалзан газрын тухай хууль тогтоомжид заасан хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газрын тэг гортигийг шинэчлэх асуудлыг судлан зохих арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | 15 сумын суурин газрын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоож .shp файлыг ГЗБГЗЗГ-т цахимаар хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ГХБХБГ-ын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1/458 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | 109 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | Тоон гарын үсгийг бүртгэлийн 16 нэгжээр дамжуулан олгож байгаа бөгөөд 16-аас дээш насны 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос өнөөдрийн байдлаар 10982 иргэн буюу 34,0 хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 9753 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 1129 иргэнд гар утасны gsign app-аар дамжуулан олголоо.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих | 30% | 30% | |
| 31 | 110 | 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар | XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга | 4.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэртээ асран хамгаалдаг 3 ээжийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл, нийгмийн халамжийн сангаас олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнийн бүлийн төсөлд хамруулан хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж ажиллалаа. Сайнцагаан сумын Мандал сургууль, Говийн-Ирээдүй цогцолбор сургууль, Хулд, Өндөршил, Сайхан-Овоо, Дэрэн сумдын ерөнхий боловсролын | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022_33 | нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга | сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хүүхэд хөгжлийн танхимтай болоод байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах төслийн зохицуулагчийг аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоог хангах зөвлөлд гишүүнээр нэмж оруулсан ба боловсролд хамруулах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилоод байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сэргээн засах үйлчилгээг “Аясал” “Эвт ган эрхэс” ХХК-тай хамтран зохион байгуулж нийт 66 иргэнд үйлчилгээ үзүүлэн 10,4 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулаад байна. 4.10. ХНХЯам, Азийн хөгжлийн банкнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний “Хөгжлийн төв”-ийн барилгыг Дундговь аймагт барьж ашиглалтад хүлээн авсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Боломжийг бүгдэд” аяныг 2 сарын хугацаанд зохион байгуулж, затологи гарган 15 сум, 24 агентлагийн 108 байгууллагаар аялуулан 46 иргэний бүтээгдэхүүнийг худалдан, 44,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс түлшний хөнгөлөлтийн материалыг хүлээн авч, түлшний хөнгөлөлтийг олгож байна. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; 4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.8. хөгжлийн бэрхшээлтэй | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.9. харьялах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | | | | |
| 32 | 111 | 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42 | ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалаар батлагдсан “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо ”-ны журмыг хэрэгжүүлэх хүрээнд 5 удаагийн цахим хурлаар, 8 удаа албан бичгээр зөвлөмж, заавар, ажлын чиглэлийг өглөө. Мөн 1,5 тэрбум төгрөгөөр Эрүүл мэндийг дэмжих төвийг ашиглалтад оруулан эрт илрүүлэлтийн үзлэг шинжилгээ, оношлогоог хийж байна. Зорилтот насны иргэдийг хамруулах үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлж 6 бүлэг насны багцын үзлэгт 25300 хүн хамрагдахаас насанд хүрэгчдийн 4 багц үзлэгт 3943, 0-18 насны 2 багц үзлэгт 8327 хүүхэд тус тус хамруулж хамрагдалтын хувь 48,5 байна.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих<br><br>Хавсралт : 2 зураг | 30% | 30% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | 112 | 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2022-10-05 Дугаар 2022_48 | XII.3.2.4. Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авч, 2022 оны 10 дугаар сард багтаан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагад. | Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ыг дагуу зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 12 дугаар хуралдаанаар хүчингүй болгуулан шийдвэрийг Хууль зүйн дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | 100% | 100% | |
| 34 | 113 | 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49 | XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав. | “Үндэсний дата төв”-д УТҮГ-ын үүлэн системд байршуулах хүсэлтийг хүргүүлсэн. Үндэсний дата төв”-ийн үүлэн серверийн үйлчилгээ түр хойшлогдсон. | Х.Б | Х.Б | |
| 35 | 114 | 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54 | Х.11.2. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч | Аймгийн хэмжээнд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 159 албан тушаалтан ажиллаж байгаа бөгөөд "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ыг ашиглаж байна. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нарт; | | | | |
| | 115 | | X.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх ажлыг орон нутагт удирдлагаар хангаН зохион байгуулж холбогдох бүх судалгааг авсан. Өндөршил, Сайхан-Овоо сумын сургуулийн эзэмшил газар зөрчилтэй байсныг холбогдох шатны байгууллагад хандаж Өндөршил сумын зөрчлийг арилгуулсан. Сайхан-Овоо сумын ЗДТГазарт газрын даамал хариуцсан орон тооны мэргэжлийн хүн байхгүй байгаа тул газрын зөрчил одоогоор шийдвэрлэгдээгүй байна. | 70% | 70% | |
| 36 | 116 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.5. . Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Отор нүүдлийн шилжилт, | Аймаг, сумд хооронд байгуулсан гэрээний дагуу мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал үүслийн гэрчилгээг үндэслэн отор нүүдлийн шилжилт, хөдөлгөөнийг хийлгэж байна. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөдөлгөөнийг мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал үүслийн гэрчилгээг үндэслэх, тархвар зүйн асуумжийн дагуу зохион байгуулан ажиллах талаар аймаг, сумд хооронд гэрээ байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт; | | | | |
| | 117 | | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох албан бичиг солилцооны дундын системийг аймгийн төрийн байгууллагуудын дотоод удирдлагын цахим Erp.e-mongolia.mn системд нэвтрүүлж албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд оролцогч албан хаагчдад албан тушаалын тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулж байна. | 70% | 70% | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | |
| 37 | 118 | Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 | 5. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, аймаг, сумдын Засаг дарга нарт: 1.1. Улаанбаатар | 1.1. Гэр хорооллыг хөгжүүлэх ажлын хүрээнд аймгийн төвийн багуудад жишиг гудамж байгуулах ажлыг тус аймгийн Сайнцагаан сумын 8 дугаар баг Айраг багийн 9 дүгээр гудамжинд хэрэгжүүлж байгаа бөгөөд тус тохижилтын “Дундговь-Ус” ОНӨҮГ орон нутгийн хөгжлийн сангийн 199,9 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 50 хувьтай байна. Дээрх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2022_5 | хот, аймаг, сумдад гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын санал боловсруулах; 1.2. Гэр хороололд сургууль, цэцэрлэг байгуулах судалгаа, төлөвлөлт, хийх, гэр хорооллын иргэдэд түргэн тусламж, гал унтраах зэрэг тусламж үйлчилгээг шуурхайг хүргэх зорилгоор гудамжны орц гарцыг сайжруулах санал боловсруулах; 1.3. Гэр хорооллын хог хаягдал, хөрсний бохирдол, жорлонгийн асуудлыг шийдвэрлэх, ногоон байгууламж барих, төлөвлөгөө, шийдлийг танилцуулах. | байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн 289,8 сая төгрөгөөр аймгийн төвийн багуудад хүүхдийн тоглоомын жишиг талбай байгуулах ажлыг 3 байршилд хэрэгжүүлсэн. 1.2. Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа сургууль, цэцэрлэгийн барилгын нэгдсэн судалгаа гаргасан. Үүнээс ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулгаж, дахин төлөвлөх, их засвар, өргөтгөл хийх ажлыг улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Гэр хорооллын иргэдэд түргэн тусламж, гал унтраах зэрэг тусламж үйлчилгээг шуурхай хүргэх бүрэн боломжтой. 1.3 2022 оны аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 33 байршил 750,91 га газрыг ногоон байгууламжийн зориулалтаар олгохоор тусгасан бөгөөд тус онд 21 байршилд 579,78га газрыг зориулалтаар нь олгосон.<br><br>Хавсралт : 7 зураг | | | |
| 38 | 119 | Нийслэлийн цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, 2022-2023 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай 2022-07-28 Дугаар 2022_7 | 4. Монгол Улсын болон орон нутгийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 80-с дээш хувийн гүйцэтгэлтэй боловсролын байгууллагын барилга байгууламжийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор ашиглалтад бүрэн оруулах арга хэмжээ авах, гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг саадгүй олгох, шаардлагатай тохиолдолд магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан нэмэлт зардлыг 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд | Төсвийн хөрөнгө оруулалтаар Сайхан-овоо суманд баригдаж буй 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, спорт зал 100 хувийн гүйцэтгэлтэй, Гурвансайхан суманд баригдаж байгаа 100 хүүхдийн дотуур байрны барилга 100 хувийн гүйцэтгэлтэй 2022 онд ашиглалтад оруулаад байна.<br><br>Хавсралт : 4 зураг | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| 39 | 120 | 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай 2022-08-01 Дугаар 2022_9 | 3. 3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 3.1. “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 277 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөц”-ийг тогтоосон хэмжээнд бүрдүүлж ажиллах; 3.2. Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах; 3.3. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хүн амыг чанарын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой, хүртээмжтэй хангах, өвөл, хаврын улирлын хэрэгцээнд шаардагдах махны нөөцийг | 3.1 Аймгийн хэмжээнд аюулгүй нөөцийн өвс, тэжээл 93,4 хувьтай бэлтгэл хангагдсан3.2 Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө батлуулан төлөвлөгөөний хэрэгжилт 88.8 хувьтай. 3.3 Өвөл, хаврын улирлын махны хэрэгцээг хангах, үнийг тогтвортой байлгах зорилгоор махны худалдаа эрхлэгч аж ахуй нэгж, иргэд нийт 352,8 тн махыг зориулалтын хөргүүртэй агуулахад нөөцөлсөн байна. 3.4 Биржид 12 төрлийн судалгааг авч нэгтгэн хүргүүлсэн. 3.5 Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдууд сум дундын отрын бүс нутаг болох 73,0 мянган га талбайд 11,0 мянган толгой мал оторлож байна. 3.6 Хадлангийн бүс нутаг байхгүй 3.7 Төсөл хөтөлбөр, орон нутгийн хөрөнгөөр 6 суманд шинээр гарсан инженерийн хийцтэй 7 худгийг 9 сард хүлээн авсан. 3.8 Малын тоо толгойн албан татварын орлого 88.4 хувьтай байна. 3.9 Зудтай тэмцэх төлөвлөгөө гарган хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. 3.10. Ургац хураалтын мэдээгээр нийт 66,3 га-аас 423,2 тн-ийг хурааж , урьд онтой харьцуулахад 3 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 3.11.Аймгийн хэмжээнд 155 тариаланч бүртгэгдэхээс одоогоор 107 тариаланч системд бүртгэгдэж бүртгэл 69 хувьтай байна. Төмс, хүнсий ногоогоо зарж борлуулах иргэн, аж ахуйн нэгжийн гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгох ажлыг эхлүүлээд байна. 3.12.Аймаг орчимд малтай иргэдийг нийтийн эзэмшлийн буюу тариалангийн талбайд тарьсан, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мод руу мал оруулахгүй байхыг цахим болон facebook хуудсаар иргэдэд мэдээллийг хүргэн ажиллаж байна. 3.13. Газар тариалангийн бүс нутагт хамрагдахгүй тул хэрэгжилтийг тооцох боломжгүй. 3.14. Сайнцагаан сумын хэмжээнд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ худалдан борлуулах зөөврийн чингэлгийг төв зах | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, нөөцийн махны чанарт онцгой анхаарч ажиллах; 3.4. Малын арьс, ширэнд анхан шатны боловсруулалт хийлгэж, Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах зохион байгуулалтын арга хэмжээ авах; 3.5. Аймаг, сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц газрын хил заагийг тодорхойлж, харьяалах аймаг, сумдад өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах; 3.6. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах асуудлын хүрээнд говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан, гар тэжээл бэлтгэхэд нь зохих дэмжлэг үзүүлж ажиллах; 3.7. Орон нутагт хийгдэж байгаа инженерийн хийцтэй худгийн чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах; 3.8. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах; 3.9. Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хууль тогтоомж, батлагдсан | болон томоохон худалдааны төвийн талбайд байрлуулсан.Төмс, хүнсний ногоо , жимс жимсгэнийг нийт 65 тн-ийг борлуулж 78.5 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж байна. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөөний дагуу шуурхай авч хэрэгжүүлэх; 3.10. Ургацын урьдчилсан балансыг таримлын төрөл бүрээр 8 дугаар сарын 18-ны дотор нарийвчлан гаргаж, таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавжаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга ажиллагаа, ургац хураалтын үед баримтлах технологийн ерөнхий зөвлөмжөөр тогтмол хангаж, ургац хураалтын мэдээ, тайланг үнэн зөв гаргах; 3.11. Газар тариалангийн мэдээллийн нэгдсэн санд тариаланчид, тариалангийн талбай, ургацыг бүртгэх цахим системийг нэвтрүүлж, гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгох ажлыг зохион байгуулах; 3.12. Ургацыг малаас хамгаалах, ургац хураалтын ажил дуусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд малчин, мал бүхий этгээдийг суурьшуулахгүй байх, малыг байнгын хариулгатай байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах; 3.13. Сортын үрийн хянан баталгааг хугацаанд нь хийх, дараа оны тариалалтад зориулан нөөцлөх үрийн цэвэрлэгээг | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгаж, стандарт шаардлагад нийцүүлэх, ногооны зоорь, агуулах, үтрэмийн цэвэрлэгээ, ариутгал, бүтээгдэхүүний хадгалалтад байнгын хяналт тавьж ажиллах; 3.14. Төвлөрсөн хот, суурин газар, төв замын дагуу төмс, хүнсний ногооны борлуулалтын цэг ажиллуулахад дэмжлэг үзүүлэх; | | | | |